



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/96/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2020 он

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34 Вэб сайт: dornogovi@audit.gov.mn <u>2020.02.28</u> № <u>1-6/210</u> танай _____-ны № _____-т	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨВСГӨЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ З.МӨНГӨНБАГАНА ТАНАА
Аудитын гэрчилгээ	
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.	
Зөрчилгүй санал дүгнэлт	
Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.	
Санал дүгнэлтийн үндэслэл	
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.	
Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.	
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.	

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 3.Мөнгөнбагана Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, өглөг, авлагын тооцоог барагдуулах, тооцоо нийлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа Уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Боловсролын чанарын хүртээмжийг иргэн бүрт тэгш хүртээж Суралцагч бүрийн сурлагын чанарт ахиц гаргахад оршино.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна..

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 579,281.5 мянган төгрөгөөс тооцон 5,792.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,792.8 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,068.2 мянган төгрөгөөр буюу 2,74 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	414.4	11.4	(403.0)
Бараа материал	55,594.8	55,640.7	45.9
Үндсэн хөрөнгө	1,698,916.3	1,651,205.2	(47,711.1)
Нийт хөрөнгө	1,754,925.5	1,706,857.3	(48,068.2)
Өр төлбөр	191.1	0	(191.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,754,734.4	1,706,857.3	(47,877.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,754,925.6	1,706,857.3	(48,068.2)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь нийгмийн даатгалаас үүссэн авлагыг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл буурсан нь харилцагч байгууллагатай тооцоо нийлж өр төлбөрийг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төлбөртэй сурах бичгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлийн зардал болон акталж угсасан хөрөнгө байгаагаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6 хөтөлбөрт зориулан 498,667.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 498,667.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 468,687.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 28,980.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 493,008.1 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас 2,022.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,981.2 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гарснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,459.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс Хангамж бараа, материалын зардалд 2,344.7 мянга, Эд хогшил худалдан авах зардалд 644.7 мянга, Томилолт, зочны зардалд 400.0 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 70.0 мянга нийт 3,459.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 191,800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 191,800.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 191,800.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 336.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 акт тогтоосноос 336.7 мянган төгрөгийн актыг барагдуулж ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагуудтай 191,800.0 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгааг хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Харилцагч байгууллагууд авлага, өр төлбөрөө хүлээн зөвшөөрөхгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг гаргахгүй байх, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгаа хийж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56 009 318,62	55 652 076,60
33	АВЛАГА	414 461,00	11 400,00
33500	Бусад авлага	414 461,00	11 400,00
33510	Байгууллагаас авах авлага	414 461,00	11 400,00
35	БАРАА МАТЕРИАЛ	55 594 857,62	55 640 676,60
35100	Түүхий эд материал	190 200,00	190 200,00
35130	Эм боох материал	190 200,00	190 200,00
35400	Хангамжийн материал	54 164 657,62	54 210 476,60
35410	Бичиг хэргийн материал	2 615 360,20	5 183 097,20
35420	Аж ахуйн материал	34 233 248,40	31 843 083,40
35440	Түлш, шатах тослох материал	2 946 179,02	105 600,00
35450	Барилгын засварын материал	766 350,00	20 000,00
35460	Хүнсний материал	629 170,00	4 084 346,00
35470	Бусад хангамжийн материал	12 974 350,00	12 974 350,00
35600	Мал амьтад	1 240 000,00	1 240 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1 698 916 260,48	1 651 205 178,45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 698 916 260,48	1 651 205 178,45
39200	Биет хөрөнгө	1 672 078 260,48	1 624 433 178,45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 518 773 540,00	1 518 773 540,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0	-32 948 325,00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0	30 500 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	-1 906 249,98
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	143 677 947,71	134 162 085,81
39206	Хуримтлагдсан элэгдэл	-74 160 639,81	-85 460 379,70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79 155 564,53	78 065 478,66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37 639 785,99	-47 405 736,74
39214	Бусад үндсэн хөрөнгө	35 003 110,00	25 103 110,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4 697 000,62	-8 041 648,26
39217	Ном	11 965 524,66	13 591 303,66
39300	Биет бус хөрөнгө	26 838 000,00	26 772 000,00
39301	Програм хангамж	705 000,00	705 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-375 000,00	-441 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	26 508 000,00	26 508 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1 754 925 579,10	1 706 857 255,05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	191 083,92	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	191 083,92	0
41300	Өглөг	191 083,92	0
41360	Бусад өглөг	191 083,92	0
41361	Байгууллагад төлөх өглөг	191 083,92	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1 754 734 495,18	1 706 857 255,05
51	Засгийн газрын хувь оролцоо	1 754 734 495,18	1 706 857 255,05
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	321 619 099,90	313 499 099,90
51200	Хуримтлагдсан үр дүн	364 690 537,04	325 358 911,29
51210	Өмнөх үеийн үр дүн	771 441 716,43	365 049 846,42
51220	Тайлант үеийн үр дүн	-406 751 179,39	-39 690 935,13
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 068 424 858,24	1 067 999 243,86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 754 925 579,10	1 706 857 255,05

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	475 362 756,00	539 590 587,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33 551 356,00	41 922 687,00
120	Нийтлэг татварын бус орлого	33 551 356,00	41 922 687,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33 551 356,00	41 922 687,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2 113 050,00	3 459 400,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31 438 306,00	38 463 287,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441 811 400,00	497 667 900,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	436 917 800,00	468 687 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4 893 600,00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	28 980 200,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	28 980 200,00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	501 385 653,44	579 281 522,13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501 385 653,44	579 281 522,13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461 744 329,44	560 642 095,06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290 102 621,00	343 567 425,00
210101	Үндсэн цалин	231 022 776,00	252 015 979,00
210102	Нэмэгдэл	27 380 360,00	62 358 546,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	26 326 668,00	29 192 900,00
210105	Гэрээт ажлын хөлс	5 372 817,00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35 559 045,00	43 922 959,20
210201	Тэтгэврийн даатгал	31 514 484,00	30 314 215,00
210202	Тэтгэмжийн даатгал	994 689,00	3 093 496,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	821 322,00	2 473 163,00
210204	Ажилгүйдлийн даатгал	201 512,00	587 804,00
210205	Эрүүл мэндийн даатгал	2 027 038,00	7 454 281,20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24 291 766,90	29 942 730,91
210301	Гэрэл, цахилгаан	6 687 145,00	7 345 918,81
210302	Түлш, халаалт	15 630 221,90	19 065 812,10
210303	Цэвэр, бохир ус	1 974 400,00	3 531 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 475 844,00	21 346 922,92
210401	Бичиг хэрэг	1 184 150,00	2 565 600,00
210402	Тээвэр, шатахуун	1 871 920,00	3 380 456,92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	48 450,00
210404	Ном, хэвлэл	76 000,00	3 444 221,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	596 000,00	137 700,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 747 774,00	11 770 495,00
2105	Нормативт зардал	30 763 390,00	32 762 096,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105 000,00	500 000,00
210502	Хоол, хүнс	30 658 390,00	32 262 096,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 544 400,00	3 649 400,00
210604	Урсгал засвар	1 544 400,00	3 649 400,00
2107	Томилолт, зочны зардал	618 800,00	2 820 600,00

210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	618 800,00	2 820 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 033 000,00	1 167 200,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 033 000,00	1 167 200,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72 355 462,54	81 462 761,03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175 586,00	95 400,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 369 800,00	483 500,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70 810 076,54	80 883 861,03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39 641 324,00	18 639 427,07
2132	Бусад урсгал шилжүүлэг	34 520 300,00	13 979 600,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13 501 500,00	13 179 600,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20 818 800,00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200 000,00	800 000,00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5 121 024,00	4 659 827,07
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5 121 024,00	4 659 827,07
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-26 022 897,44	-39 690 935,13
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	380 728 281,95	0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4 032 208,80	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	107 800,13	0
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	376 588 273,02	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-406 751 179,39	-39 690 935,13

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	443 924 450,00	501 127 300,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443 924 450,00	501 127 300,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	436 917 800,00	468 687 700,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	436 917 800,00	468 687 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7 006 650,00	3 459 400,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4 893 600,00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2 113 050,00	3 459 400,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0	28 980 200,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0	28 980 200,00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	439 679 600,00	492 752 300,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439 679 600,00	492 752 300,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400 175 971,00	474 112 872,93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	290 710 689,00	343 144 107,00
210101	Үндсэн цалин	178 147 641,00	201 519 952,00
210102	Нэмэгдэл	63 222 898,00	99 281 702,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	28 275 679,00	42 342 453,00
210105	Гэрээт ажлын хөлс	21 064 471,00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38 771 437,00	44 009 521,20
210201	Тэтгэврийн даатгал	27 494 285,00	31 419 000,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 847 700,00	2 580 021,20
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 270 552,00	3 128 700,00
210204	Ажилгүйдлийн даатгал	643 900,00	625 900,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5 515 000,00	6 255 900,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22 190 845,00	26 777 218,81
210301	Гэрэл, цахилгаан	6 687 145,00	6 795 918,81
210302	Түлш, халаалт	13 550 900,00	16 450 300,00
210303	Цэвэр, бохир ус	1 952 800,00	3 531 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	7 514 373,00	9 567 120,92
210401	Бичиг хэрэг	871 578,00	475 900,00
210402	Тээвэр, шатахуун	2 056 680,00	2 698 790,92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	6 450,00
210404	Ном, хэвлэл	84 000,00	1 074 600,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	586 000,00	171 100,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 916 115,00	5 140 280,00
2105	Нормативт зардал	29 212 511,00	36 886 436,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	181 800,00	500 000,00
210502	Хоол, хүнс	28 581 491,00	35 619 036,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	449 220,00	767 400,00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 497 825,00	2 839 355,00
210602	Тавилга	0	27 200,00
210604	Урсгал засвар	2 497 825,00	2 812 155,00
2107	Томилолт, зочны зардал	457 800,00	2 194 700,00
210702	Дотоод албан томилолт	457 800,00	2 194 700,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 171 491,00	991 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1 171 491,00	991 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7 649 000,00	7 703 414,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	495 000,00	204 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7 154 000,00	7 499 414,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39 503 629,00	18 639 427,07
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	34 316 300,00	13 979 600,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13 297 500,00	13 179 600,00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20 818 800,00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200 000,00	800 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	66 305,00	0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	66 305,00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0	8 326,19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	8 326,19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5 121 024,00	4 651 500,88
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5 121 024,00	4 651 500,88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4 244 850,00	8 375 000,00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4 244 850,00	8 375 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4 244 850,00	8 375 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	4 244 850,00	8 375 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4 244 850,00	8 375 000,00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4 244 850,00	-8 375 000,00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	321 619 099,90	846 180 448,93	696 220 224,51	1 864 019 773,34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	75 221 491,92	75 221 491,92
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	321 619 099,90	846 180 448,93	771 441 716,43	1 939 241 265,26
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	222 244 409,31	0	222 244 409,31
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-406 751 179,39	-406 751 179,39
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	321 619 099,90	1 068 424 858,24	364 690 537,04	1 754 734 495,18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	359 309,38	359 309,38
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	321 619 099,90	1 068 424 858,24	365 049 846,42	1 755 093 804,56
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-425 614,38	0	-425 614,38
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-8 120 000,00	0	0	-8 120 000,00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-39 690 935,13	-39 690 935,13
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	313 499 099,90	1 067 999 243,86	325 358 911,29	1 706 857 255,05

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	497 667 900,00	493 008 072,93	4 659 827,07	99,1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	497 667 900,00	493 008 072,93	4 659 827,07	99,1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481 543 900,00	479 028 472,93	2 515 427,07	99,5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	345 166 900,00	343 144 107,00	2 022 793,00	99,4
210101	Үндсэн цалин	201 906 800,00	201 519 952,00	386 848,00	99,8
210102	Нэмэгдэл	100 371 000,00	99 281 702,00	1 089 298,00	98,9
210104	Урамшуулал	42 889 100,00	42 342 453,00	546 647,00	98,7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44 480 800,00	44 009 521,20	471 278,80	98,9
210201	Тэтгэврийн даатгал	31 419 000,00	31 419 000,00	-	100,0
210202	Тэтгэмжийн даатгал	2 612 400,00	2 580 021,20	32 378,80	98,8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 265 500,00	3 128 700,00	136 800,00	95,8
210204	Ажилгүйдлийн даатгал	653 200,00	625 900,00	27 300,00	95,8
210205	Эрүүл мэндийн даатгал	6 530 700,00	6 255 900,00	274 800,00	95,8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26 780 200,00	26 777 218,81	2 981,19	100,0
210301	Гэрэл, цахилгаан	6 790 200,00	6 795 918,81	(5 718,81)	100,1
210302	Түлш, халаалт	16 460 000,00	16 450 300,00	9 700,00	99,9
210303	Цэвэр, бохир ус	3 530 000,00	3 531 000,00	(1 000,00)	100,0
2104	Хангамж, бараа материалын зардал	7 226 000,00	7 222 420,92	3 579,08	100,0
210401	Бичиг хэрэг	300 000,00	475 900,00	(175 900,00)	158,6
210402	Тээвэр, шатахуун	2 700 000,00	2 698 790,92	1 209,08	100,0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	534 000,00	6 450,00	527 550,00	1,2
210404	Ном, хэвлэл	406 000,00	84 000,00	322 000,00	20,7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282 000,00	171 100,00	110 900,00	60,7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 004 000,00	3 786 180,00	(782 180,00)	126,0
2105	Нормативт зардал	36 890 000,00	36 886 436,00	3 564,00	100,0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500 000,00	500 000,00	-	100,0
210502	Хоол, хүнс	35 620 000,00	35 619 036,00	964,00	100,0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770 000,00	767 400,00	2 600,00	99,7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10 575 000,00	10 569 655,00	5 345,00	99,9
210601	Багаж, техник, хэрэгсэл	6 950 000,00	6 950 000,00	-	100,0
210602	Тавилга	1 425 000,00	1 425 000,00	-	100,0
210604	Урсгал засвар	2 200 000,00	2 194 655,00	5 345,00	99,8
2107	Томилолт, зочны зардал	1 800 000,00	1 794 700,00	5 300,00	99,7
210702	Дотоод албан томилолт	1 800 000,00	1 794 700,00	5 300,00	99,7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	921 000,00	921 000,00	-	100,0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	921 000,00	921 000,00	-	100,0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7 704 000,00	7 703 414,00	586,00	100,0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	204 000,00	204 000,00	-	100,0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7 500 000,00	7 499 414,00	586,00	100,0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16 124 000,00	13 979 600,00	2 144 400,00	86,7
2132	Бусад урсгал шилжүүлэг	16 124 000,00	13 979 600,00	2 144 400,00	86,7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15 324 000,00	13 179 600,00	2 144 400,00	86,0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800 000,00	800 000,00	-	100,0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	497 667 900,00	493,008,072.93	4,659,827.07	100,0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	468 687 700,00	493,008,072.93	4,659,827.07	100,0
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	468 687 700,00	464,036,199.125	4,651,500.88	100,0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28 980 200,00	28,971,873.81	8,326.19	100,0
320001	Орон нутгийн төсвөөс	28 980 200,00	28,971,873.81	8,326.19	100,0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	312	312	-	100,0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100,0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100,0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37	-	100,0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100,0
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100,0
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100,0
620004	Гэрээт ажилтан	6	6	-	100,0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	237	237	-	100,0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	237	237	-	100,0

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3 459 400,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3 459 400,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3 459 400,00
2104	Хангамж, бараа материалын зардал		2 344 700,00
210404	Ном, хэвлэл		990 600,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1 354 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		644 700,00
210602	Тавилга		27 200,00
210604	Урсгал засвар		617 500,00
2107	Томилолт, зочны зардал		400 000,00
210702	Дотоод албан томилолт		400 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		70 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		70 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3 459 400,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3 459 400,00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.25			ДГА-2020/96/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна		Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Хандмаа
2	Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгааг хийгээгүй байна	191,800.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Н.Хандмаа